

**“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХК-ИЙН 2015 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**I. ТАЙЛАНГИЙН ЭХНИЙ ХЭСЭГ**

**1. Үнэт цаас гаргагчийн нэр, оршин суугаа хаяг:**

Хаяг: Дорноговь аймаг, Замын үүд сум, 1-р баг 10-р хэсэг, Э-Транс ложистикс ХК-ийн байр

Утас: 02524543813, 99117636, 88086390

Электрон хаяг: [www.etranslog.mn](http://www.etranslog.mn)

**2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл**

Компанийн нэр:	“Э-Транс Ложистикс” ХК
Улсын бүртгэлд бүртгэсэн огноо:	2011.12.06
Улсын бүртгэлийн дугаар:	0610001001
Регистерийн дугаар:	3309665
Үйл ажиллагааны чиглэл:	Ачаа шилжүүлэн ачих
Хувьцаа эзэмшигчдийн тоо:	355 хувьцаа эзэмшигчидтэй. /2014 оны 3 сарын 14-ны өдрийн тархалтын судалгаа/

**3. Үнэт цаас гаргагчийн зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл:**

Манай терминал нь Монгол улсыг Хятадтай холбосон хамгийн том боомт Дорноговь аймгийн Замын-Үүд боомтод байрладаг. Одоогийн байдлаар Хятадаас ачааны машинаар тээвэрлэгдэн импортоор орж ирж буй барилгын материал болон төрөл бүрийн ачааг вагонд, вагоноор ирж буй арьс шир, бусад төрлийн экспортын ачаа барааг ачааны машинд шилжүүлэн ачих үйлчилгээ үзүүлж байна. Эрэнээс бараа бүтээгдэхүүн оруулж ирж буй хэрэглэгчид гаалийн хяналтын бүсэд ачаа барааны бүрдүүлэлт хийж, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт өөр бусад хүссэн газар луугаа илгээж, хүлээн авах боломжтой нэг цэгийн үйлчилгээний төв юм.

Замын-Үүд боомтоос БНХАУ-руу гарах хилийн хаалгаас 100 метрийн зайд байрладаг ба хэрэглэгчдэд маш тохиромжтой байрлал юм. Ачаа ачсан хүнд даацын машинууд Төмөр замын шилжүүлэн ачих өртөө /ШАӨ/-д хүрэхэд тэдний цаг хугацаа, шатахууны зардлыг нэмэгдүүлдэг. Иймээс манай хяналтын бүс нь хэрэглэгчдэд олон төрлийн үйлчилгээг нэг дор хүргэж, шаардлагатай техник хэрэгслээр бүрэн хангагдсан шилжүүлэн ачих терминал юм.

Дараах хүчин зүйлс нь Терминалыг үр ашигтай ажиллахад нөлөөлж байна.

- Хэрэглэгчдэд хамгийн тохиромжтой байрлал
- Өндөр ур чадвартай менежмент
- Хятадын талтай хамтран Эрэнээс Замын-Үүдэд эсвэл Улаанбаатарт хүрэх тээврийн үйлчилгээгээр хангах
- Хамтран ажиллах тааламжтай нөхцөл гэх мэт олон хүчин зүйлс нь үр ашигтай ажиллах, зах зээлд эзлэх байр суурийг нэмэгдүүлж байна.
- Ачааг шилжүүлэн ачих ачилтыг хялбарчлах үүднээс туузан дамжуурга, автокран, погрузчик гэх мэт зарим механикжуулалтыг нэвтрүүлсэн.
- Гаалийн баталгаат агуулахын үйлчилгээ

- 24-н цагийн харуул хамгаалалт, IP- камерийн систем суурилуулж ачаа барааг бүрэн хянах боломжтой.

Бид цаашид тээвэр ложистикийг бүрэн утгаар нь хөгжүүлэн, олон улсыг холбосон тэргүүлэх зэрэглэлийн терминалыг Монголд бий болгох, Ачаа шилжүүлэн ачих цаг хугацаа, ажиллах хүч хэмнэх, үйл ажиллагааг хялбарчлах өндөр бүтээмжтэй техник технологийг нэвтрүүлэх, Вагонд ачих ачааны нэр төрлийг олшруулан, өөрийн нөөц бололцоог ашиглан бүхий л төрлийн вагонд ачилт хийж, вагоны цаг ашиглалтыг багасгах, сул зогсолт гаргахгүй байх үндсэн үйл ажиллагааг сайжруулах, хүний нөөцийн тогтвортой хөгжлийн бодлого хэрэгжүүлэхээр зорилт тавин ажиллаж байна.

#### 4. Үнэт цаас гаргагчийн түүх, тухайн зах зээлд эзэлж буй байр суурь, судалгаа:

Э-Транс Ложистикс ХХК-ийн толгой компани болох Э-Транс ХХК нь 1997 онд 1 гишүүнтэйгээр байгуулагдсан. Тус компани нь төмөр зам, авто зам, агаар, далайн тээвэрлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Дэлхийн 5 тивд ложистикийн байгууллагуудтай төлөөллийн гэрээгээр хамтран ажилладаг. Улаанбаатар хотод төв оффис, Замын-Үүд, Сүхбаатар хотод салбартай. Бизнесийн үндсэн чиглэл нь Орос, Хятадын хооронд Монголоор дамжуулан тээвэрлэх транзит тээврийн үйл ажиллагаа юм.

2007 оноос Ачаа шилжүүлэн ачих терминал байгуулахаар төсөл хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд уг терминал нь 2009 онд ашиглалтанд орсноор үйл ажиллагаагаа явуулж байна.

2010 онд Э-Транс ХХК нь ачаа шилжүүлэн ачих терминалын үйл ажиллагаагаа тусгаарлан Э-Транс Ложистикс ХХК-д шилжүүлсэн. 2011 онд шилжүүлэн ачих терминалын үйл ажиллагаагаа өргөжүүлэн олон төрлийн ачааг шилжүүлэн ачиж эхэлсэн.

Э-Транс ложистикс ХХК нь 2012 оны 4-р сард хөрөнгийн бирж дээр хувьцаагаа арилжаалан хувьцаат компани болж үйл ажиллагааныхаа хүрээг тэлж техник технологийн шинэчлэлийг эрчимтэй хийж эхэлсэн. Бид 2012 онд нэг цэгийн үйлчилгээний барилгаа ашиглалтанд оруулан нэг цэгийн үйлчилгээний төвөө ажиллжуулж эхэлсэн.

Э-Транс Ложистикс ХХК нь орон тооны 33 ажилчин, өдөрт орон тооны бус 70-80 ачигч нарыг ажлын байраар ханган, гаалийн хяналтын бүс, орон нутгийн ачилтын талбай, төв оффиссын үйл ажиллагаанд 24-н цагийн турш байнгын хяналт тавих IP камер, харуул хамгаалалтыг нэг ээлжиндээ 5 хамгаалагчтай байхаар зохион байгуулан гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлдэг Бодь санаа ХХК-тай хамтран ажиллаж байна.


Замын –Үүд суманд ачаа шилжүүлэн ачих терминалийн үйлчилгээ явуулж буй байгууллагуудын мэдээлэл:

Терминал	Хилийн хаалганаас зай	Үйл ажиллагааны чиглэл	Онцлог
“Э-Транс Ложистикс” ХК	100м	Монголын өргөн царигын вагон болон авто машин хооронд ачаа шилжүүлэн ачдаг.	- Нэг цэгийн үйлчилгээ - Барилгын материал болон төрөл бүрийн

			ачаа шилжүүлэн ачдаг.
Төмөр замын харьяа шилжүүлэн ачих өртөө I	6 км	Хятадын төмөр замын нарийн царигийн вагон, Монголын төмөр замын өргөн царигын вагоны хооронд хүнд даацын ачаа шилжүүлэн ачих, авто машин вагон хооронд хялбар муудах ачаа, чингэлэг шилжүүлэн ачдаг.	- Нэг цэгийн үйлчилгээ - Хүнд даацын ачаа шилжүүлэн ачдаг.
Төмөр замын харьяа шилжүүлэн ачих өртөө II	4км	Нарийн царигаас өргөн цариг руу болон автомашинаас вагон луу чингэлэг шилжүүлэн ачдаг.	- Нэг цэгийн үйлчилгээ - Эрээний агент байрладаг. - Чингэлэг шилжүүлэн ачдаг.
Төмөр замын харьяа шилжүүлэн ачих өртөө III	11 км	Автомашинаас вагон руу цемент шилжүүлэн ачдаг.	- Барилгын материал болон өргөн хэрэглээний бараа шилжүүлэн ачдаг. - Бусад үйлчилгээ байхгүй

**5. Үнэт цаас гаргагчийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбоотой үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл:**

Ачилтын график



Ачилтын тоон судалгаа

Огноо	2012 онд ачсан вагоны тоо	2013 онд ачсан вагоны тоо	2014 онд ачсан вагоны тоо
1-р сард	194	228	170
2-р сард	116	95	70

3-р сард	265	262	334
4-р сард	303	403	301
5-р сард	351	360	291
6-р сард	442	463	301
7-р сард	534	511	450
8-р сард	649	329	652
9-р сард	600	358	451
10-р сард	379	436	231
11-р сард	305	319	132
12-р сард	307	117	156
<b>Нийт дүн</b>	<b>4,445</b>	<b>3,881</b>	<b>3,539</b>

Дээрхи графикаас харахад ачааны ерөнхий хандлага 2012 оныхоос 2013 болон 2014 онд буурсан үзүүлэлттэй харагдаж бана. Энэ онд ачилтыг нэмэгдүүлэх, үндсэн үйл ажиллагаагаа эрчимжүүлэх, өмнөх оны үйл ажиллагааны түвшинд хүрэх, үйл ажиллагааны хүрээг өргөжүүлэх, судлах зэрэг зорилтыг тавин ажилласан боловч улс орны эдийн засгийн хэлбэлзэл, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын худалдан авах чадвараас шалтгаалан үйл ажиллагаа тодорхой түвшинд буурсан үзүүлэлттэй гарч байна. Гэвч цаашид ачилтыг нэмэгдүүлэх, өөр төрлийн ачаа барааны тээвэр, гар ажиллагааг механикжуулах, гэх мэт олон арга хэмжээ авч ажиллаж байна.

Манай компани нь Олон улсын стандарт бус ачаа тээврийн LARGUS компанитай хамтран 45,5 метрийн урттай салхин сэнсний хадгалалт, тээвэрлэлтийн эхний ээлжийн ачилтыг амжилттай ОХУ-аар дамжуулан Казакстан улс руу тээвэрлэн явуулж, цаашид салхин сэнсний тээвэрлэлтийг хариуцан явуулахаар өөрсдийн нөөц бололцоог ашиглан ажиллаж байна. 2013 оны 09-р сарын 20-ны өдрийн Гаалийн ерөнхий газрын даргын А/193 тоот тушаалаар 1,2-р агуулахуудыг техник тоног төхөөрөмж, бүх төрлийн бараа материалыг хадгалах зориулалттай нээлттэй гаалийн баталгаат агуулахаар зарлуулан замын үүдэд анхны гаалийн баталгаат агуулахыг ажиллуулж эхлээд байна. Цаашид гадаад дотоод харилцааг нэмэгдүүлэх тал дээр гүйцэтгэх удирдлагын зүгээс олон талт арга хэмжээг авч ажиллаж байна. Мөн бид төмөр замын тээврээс гадна авто замын тээврийг явуулах тал дээр анхаарч өөрсдийн зүгээс шаардлагатай ажлуудыг эхлүүлэх тал дээр анхаарч ажиллаж байна.

**6. Үнэт цаас гаргагчийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл:**

Компанийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл

№	Овог нэр	Албан тушаал	Хувьцааны хувь
1	Э-Транс ХХК	Ачаа тээврийн компани	50%
2	Монголиан Транспортэйшн Холдинг ХХК	Хөрөнгө оруулалтын сан, Люксембургын вант улс	6.92%
3	БиДиСек ХК	Брокер дилер, андеррайтерийн компани	26.56%

7. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга:

№	Овог нэр	Албан тушаал	Боловсрол	Ажлын туршлага
1	Чулуун овогтой Энхболд	ТУЗ-ийн дарга	Дээд	Э-Транс ХХК Ерөнхий захирал
2	Чулуун овогтой Амарсанаа	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Э-Транс Ложистикс ХК Гүйцэтгэх захирал
3	Санжмятав овогтой Отгонбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Э-Транс ХХК, Ерөнхий менежер
4	Сэджав овогтой Санжаа	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Мэдээлэл Аудит ХХК, Мэргэжилтэн
5	Баярсайхан овогтой Пүрэвбаатар	ТУЗ-ийн гишүүн	Дээд	"Си Би Эм" ХХК, Санхүүгийн шинжээч
6	Бадан овогтой Батбаатар	ТУЗ-ийн гишүүн	Дээд	"Си Би Эм" ХХК, Гүйцэтгэх захирал
7	Бүрэнмэнд овогтой Лхагвадорж	ТУЗ-ийн гишүүн	Дээд	БиДиСек ХК Тэргүүн дэд захирал
8	Ариунболд овогтой Батболд	ТУЗ-ийн гишүүн	Дээд	"Оптимальный проект" ХХК захирал
9	Халтар овогтой Батхишиг	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Нефть Ойл ХХК, Гүйцэтгэх захирал
10	Ганболд овогтой Гэрэлт-Од	ТУЗ-ийн нарийн бичиг	Дээд	

8. Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчийн мэдээлэл

№	Овог нэр	Албан тушаал	Хувьцааны хувь
1	Э-Транс ХХК	Ачаа тээврийн компани	50%
2	Монголиан Транспортэйшн Холдинг ХХК	Хөрөнгө оруулалтын сан, Люксембургын вант улс	6.92%
3	БиДиСек ХК	Брокер дилер, андеррайтерийн компани	26.56%

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн болох Чулуун овогтой Энхболд, Санжмятав овогтой Отгонбаяр, Баярсайхан овогтой Пүрэвбаатар, Бадан овогтой Батбаатар, Бүрэнмэнд овогтой Лхагвадорж болон Гүйцэтгэх захирал Чулуун овогтой Амарсанаа нар компанийн хараат гишүүд болно.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн болох Ариунболд овогтой Батболд, Халтар овогтой Батхишиг, Сэджав овогтой Санжаа нар компанийн хараат бус гишүүд болно.

## II. ТАЙЛАНГИЙН ХОЁРДАХЬ ХЭСЭГ

### 1. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Улсын хэмжээнд даган мөрддөг НББ-ийн дансны нэгдсэн зааврын дагуу үндсэн дансуудыг ангилан, туслах дансуудыг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан коджуулан хэрэглэж байгаа бөгөөд дансны жагсаалт нь баланс болон орлого, үр дүнгийн тайлангуудын дансуудаас бүрддэг.

Санхүүгийн жилийн татвар ногдох орлого, зардлаа Монгол Улсын Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хууль болон бусад холбогдох хуулийн хүрээнд бэлтгэн тайлагнадаг.

Санхүүгийн тайлангаа НББ-ийн аккруэл суурьд үндэслэн бэлтгэдэг ба холбогдох хуулийн дагуу улирлын тайлангаа дараа сарын 20-ны дотор, жилийн тайлангаа дараа оны 2 сарын 10-ны дотор баталгаажуулан Төрийн сан болон Татварын хэлтэс, МХБ, СЗХ зэрэг байгууллагуудад хүргүүлдэг.

Мөн бид санхүүгийн тайлангаа өөрийн веб сайтандаа байршуулдаг ба энэ нь манай дотоодын харилцагч нараас гадна дэлхийн аль ч улс орноос харилцагчид санхүүгийн мэдээллийг бодитой, шуурхай авах боломжийг олгодог.

Санхүүгийн тайланг алдаа зөрчилгүй илэрхийлснээ нотлон хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулан Хараат бус аудиторын дүгнэлт гаргуулдаг бөгөөд 2014 оны тайлант жилд Нийслэл аудит ХХК-тай хамтран ажиллаад байна.

### 2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ОРЛОГЫН ТАЙЛАН

№	Үзүүлэлт	Тодруулга	2013	2014
			мян.төг	мян.төг
1	Тээвэр зуучийн орлого	3	5,354,657.10	5,298,010.0
2	Үзүүлсэн үйлчилгээний өртөг	4	4,429,109.40	4,819,423.4
3	<b>Нийт ашиг</b>		<b>925,547.70</b>	<b>478,586.60</b>
4	Түрээсийн орлого		38,290.90	41,327.3
5	Хүүний орлого	5	1,149.30	1,621.9
6	Бусад орлого		34,269.90	57,942.2
7	Удирдлагын зардал	6	842,194.30	375,477.5
8	Санхүүгийн зардал	7	-	51,893.8
10	Гадаад валютын ханшны зөрүүний гарз	8	-	(50,766.0)
11	Үйл ажиллагааны бус зардал		74,783.70	41,694.8
12	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>		<b>82,279.80</b>	<b>59,645.9</b>
13	Орлогын татварын зардал	9	9,048.40	16,669.0
14	<b>Тайлант үеийн цэвэр ашиг</b>		<b>73,231.40</b>	<b>42,976.9</b>
15	Нэгж энгийн хувьцаанд ногдох ашиг, төгрөгөөр		1.58	0.93

## Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮГИЙН  
БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тодруулга	2013.12.31 мян.төг	2014.12.31 мян.төг
<b>ХӨРӨНГӨ</b>			
<u>Эргэлтийн Хөрөнгө</u>			
Мөнгөн хөрөнгө	10	48,099.0	21,211.7
Дансны авлага	11	17,286.7	37,215.7
Бусад авлага	12		2,452.8
Хангамжийн материал	13	59,983.2	73,349.6
Эргэлтийн хөрөнгийн дүн	14	<b>125,368.9</b>	<b>134,229.8</b>
<u>Эргэлтийн бус хөрөнгө</u>			
Үндсэн хөрөнгө	15	6,080,667.5	6,125,232.8
Хуримтлагдсан элэгдэл		(483,767.4)	(689,623.8)
Биет бус хөрөнгө	16	952,832.7	880,677.6
Хойшлогдсон татварын хөрөнгө	17	6,534.9	3,834.1
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		<b>6,556,267.7</b>	<b>6,320,120.7</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>6,681,636.6</b>	<b>6,454,350.5</b>
<b>ӨӨРИЙН ХӨРӨНГӨ БА ӨР ТӨЛБӨР</b>			
<u>Богино хугацаат өр төлбөр</u>			
Дансны өглөг	18	448,911.2	258,365.4
Орлогын татварын өглөг		6,432.1	7,798.1
Банкны богино хугацаат зээл	19	381,706.8	313,083.5
Урьдчилж орсон орлого		12,460.0	
Богино хугацаат өр төлбөрийн дүн		<b>849,510.1</b>	<b>579,247.0</b>
<u>Урт хугацаат өр төлбөр</u>			
Урт хугацаат зээл		-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		-	-
Өр төлбөрийн нийт дүн		<b>849,510.1</b>	<b>579,247.0</b>
<u>Эздийн өмч</u>			
Энгийн хувьцаа	20	4,620,000.0	4,620,000.0
Нэмж төлөгдсөн капитал	21	154,000.0	154,000.0
Хуримтлагдсан ашиг	22	235,126.5	278,103.5
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	23	823,000.0	823,000.0
Эздийн өмчийн дүн		<b>5,832,126.5</b>	<b>5,875,103.5</b>
<b>НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ БА ӨР</b>		<b>6,681,636.6</b>	<b>6,454,350.5</b>

Э-ГРАНС ЛОЖИСТИКС ХК

2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН  
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Энгийн хувьцаа (мян.төг)	Нэмж төлөгдсөн капитал (мян.төг)	Хуримтлагдсан ашиг (мян.төг)	Эздийн өмчийн бусад хэсэг (мян.төг)	Нийт дүн (мян.төг)
<b>2012.12.31 нэрх үлдэгдэл</b>	<b>4,620,000.0</b>	<b>154,000.0</b>	<b>161,895.20</b>	<b>823,000.0</b>	<b>5,758,895.2</b>
Эзний нэмж оруулсан хөрөнгө					-
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Ногдол ашиг			73,231.40		73,231.4
2013 оны татварын дараах ашиг					
<b>2013.12.31 нэрх үлдэгдэл</b>	<b>4,620,000.0</b>	<b>154,000.0</b>	<b>235,126.6</b>	<b>823,000.0</b>	<b>5,832,126.6</b>
Эзний нэмж оруулсан хөрөнгө					
Бусад дэлгэрэнгүй орлого					
Ногдол ашиг			42,976.9		42,976.9
2014 оны татварын дараах ашиг					
<b>2014.12.31 нэрх үлдэгдэл</b>	<b>4,620,000.0</b>		<b>278,103.5</b>		<b>5,875,103.5</b>



## Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК

2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН  
ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

№	Үзүүлэлт	2013.12.31	2014.12.31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,474,547.6	5,432,100.4
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,471,139.2	5,425,314.0
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан	105.0	3,577.7
	Буцаан авсан албан татвар	1,085.1	
	Бусад мөнгөн орлого	2,218.3	3,208.7
1.2	Мөнгөн зарлага (-)	5,159,848.5	5,147,594.9
	Ажиллагчдад төлсөн	166,793.5	207,593.0
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	17,976.0	22,043.3
	Бараа материал худалдан авахад төлсөн	356,839.8	398,050.3
	Ашиглалтын зардалд төлсөн	55,860.7	62,457.8
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,438,157.7	4,254,168.9
	Хүүний төлбөрт төлсөн	47,173.8	49,821.4
	Татварын байгууллагад төлсөн	47,742.2	114,913.9
	Даатгалын төлбөрт төлсөн	3,070.5	
	Бусад мөнгөн зарлага	26,234.3	38,546.3
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>314,699.1</b>	<b>284,505.5</b>
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,149.3	1,587.6
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Хүлээн авсан хүүний орлого	1,149.3	1,587.6
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүй</b>	<b>1,149.3</b>	<b>1,587.6</b>
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		16,902.0
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		16,902.0
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	294,893.1	329,882.4
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	294,893.1	329,882.4
	Төлсөн ногдол ашиг		
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний</b>	<b>(294,893.1)</b>	<b>(312,980.4)</b>
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	20,955.3	(26,887.3)
5	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,143.7	48,099.0
6	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	48,099.0	21,211.7



# “НИЙСЛЭЛ-АУДИТ” ХХК

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

2015 оны 02 сарын 12 өдөр

Улаанбаатар хот

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК -ийн хувьцаа эзэмшигчдэд

Бид Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

#### Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь компанийн Гүйцэтгэх удирдлагын хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад санхүүгийн ажил гүйлгээнд тохирох нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогыг сонгон авч хэрэглэх, нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг үнэн зөв хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлийг агуулаагүй санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулах, энэхүү үйл явцтай холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх асуудал багтана.

#### Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн энэхүү санхүүгийн тайлангийн талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний хариуцлага юм.

Бид танай санхүүгийн тайланг материаллаг алдаагүй бэлтгэгдсэн тухай найдвартай, хангалттай нотолгоо олж авах зорилгоор аудитыг төлөвлөж Аудитын Олон улсын Стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тогтоомж, манай компанийн “Аудит хийх журам”-ыг баримтлан хийв. Аудит хийхдээ түүвэрлэсэн анхны баримтаас тайлан хүртэл хөөн шалгах, давтан тооцоолох, тулган баталгаажуулах, задлан шинжлэх, асууж ярилцах зэрэг аудитын горимуудыг ашиглав. Бидний хийсэн аудит нь санхүүгийн тайлангийн талаар санал, дүгнэлтээ илэрхийлэх хангалттай үндэслэлийг бий болгосон гэдэгт итгэлтэй байна.

**Дүгнэлт**

Бидний дүгнэлтээр энэхүү санхүүгийн тайлан нь 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн зөв, бодитой үзүүлсэн байна.

**Бусад**

Энэ дүгнэлтийг өөр аливаа нэг этгээдэд биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан, тэдний хүсэлтээр хийсэн аудитад үндэслэн гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



Т.СУГАРСҮРЭН

2. Компани нь 2014 оны байдлаар 278,1 сая төгрөгийн хуримтлагдсан ашигтай байгаа ба өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс их байна.
3. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ, тэдгээр нь үнэт цаас эзэмшдэг талаархи мэдээлэл:

№	Овог нэр	Цалин урамшууллын хэмжээ	Хандив тусламжийн хэмжээ	Бусад	Эзэмшиж буй хувьцааны тоо
1	Чулуун овогтой Энхболд	0₮		ТУЗ-ийн дарга	Эзэмшдэггүй
2	Чулуун овогтой Амарсанаа	Сарын 1.000.000₮		ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал	Эзэмшдэггүй
3	Санжмятав овогтой Отгонбаяр	0₮		ТУЗ-ийн гишүүн	Эзэмшдэггүй
4	Сэджав овогтой Санжаа	0₮		ТУЗ-ийн гишүүн	Эзэмшдэггүй
5	Баярсайхан овогтой Пүрэвбаатар	0₮		ТУЗ-ийн гишүүн	Эзэмшдэггүй
6	Бадан овогтой Батбаатар	0₮		ТУЗ-ийн гишүүн	Эзэмшдэггүй
7	Бүрэнмэнд овогтой Лхагвадорж	0₮		ТУЗ-ийн гишүүн	Эзэмшдэггүй
8	Ариунболд овогтой Батболд	0₮		ТУЗ-ийн гишүүн	Эзэмшдэггүй
9	Халтар овогтой Батхишиг	0₮		ТУЗ-ийн гишүүн	700,000ширхэг, 1,5%
10	Ганболд овогтой Гэрэлт-Од	Сарын 20.000₮		ТУЗ-ийн нарийн бичиг	Эзэмшдэггүй

#### 4. Ногдол ашгийн талаархи мэдээлэл

Компани нь өөрийн үйл ажиллагааг өртгөтгөх зорилгоор эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх тал дээр анхаарч Хас банкнаас зээл авсан ба зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан ногдол ашиг олгоогүй байна.

#### 5. Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаархи мэдээлэл

Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний гэрээ хэлцэл хийгдээгүй болно.

#### 6. Үнэт цаас гаргагчийн ТУЗ, дэд хороодын үйл ажиллагааны тайлан

	овог, нэр	Эрхэлдэг ажил	Эзэмшсэн мэргэжил, боловсрол	Эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь	Хараат бус гишүүн эсэх
1	Чулуун овогтой Энхболд	Э-Транс ХХК Ерөнхий захирал	Ленинградын Төмөр замын дээд сургууль, Төмөр замын инженер	Эзэмшдэггүй	Энгийн
2	Чулуун овогтой	Э-Транс	ЗХУ-ын Свердловск	Эзэмшдэггүй	Энгийн

	Амарсанаа	Ложистикс ХК Гүйцэтгэх захирал	хотын Уулын дээд сургууль, Уулын инженер		
3	Санжмятав овогтой Отгонбаяр	Э-Транс ХХК, Ерөнхий менежер	Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль, Бизнесийн удирдлага	Эзэмшдэггүй	Энгийн
4	Сэджав овогтой Санжаа	Мэдээлэл Аудит ХХК, Мэргэжилтэн	Санхүү Эдийн Засгийн Техникум	Эзэмшдэггүй	Энгийн
5	Баярсайхан овогтой Пүрэвбаатар	"Си Би Эм"ХХК, Санхүүгийн шинжээч	University Tomas Bata in Zlin8 Czech Republiv, Business Administration	Эзэмшдэггүй	Энгийн
6	Бадан овогтой Батбаатар	"Си Би Эм"ХХК, Гүйцэтгэх захирал	The George Washington их сургууль, Бизнесийн удирдлага	Эзэмшдэггүй	Энгийн
7	Бүрэнмэнд овогтой Лхагвадорж	БиДиСек ХК Тэргүүн дэд захирал	ШУТИС, Нефтийн инженер	Эзэмшдэггүй	Хараат бус
8	Ариунболд овогтой Батболд	"Оптималь проект"ХХК захирал	Санкт-Петербургийн төмөр замын дээд сургууль	Эзэмшдэггүй	Хараат бус
9	Халтар овогтой Батхишиг	Нефть Ойл ХХК, Гүйцэтгэх захирал	ШУТИС, Нефтийн инженер	700,000ширхэг, 1,5%	Хараат бус

Компани нь 2014 оны 04 сарын 28-ны өдөр "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал"-ыг зарлан хуралдуулж, ТУЗ-ын гишүүдийг сонгосон бөгөөд 2014 оны 04 сарын 29-ний өдөр ТУЗ-ийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хороог Б.Батбаатар, А.Батболд, Б.Лхагвадорж гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус Б.Лхагвадорж гишүүнийг томилсон.
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хороог Ч.Энхболд, С.Санжаа, Б.Лхагвадорж гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин, урамшууллын хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Ч.Энхболдыг томилсон.
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороог Ч.Энхболд, Х.Батхишиг, С.Санжаа гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Нэр дэвшүүлэх хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Ч.Энхболдыг томилсон.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2014 онд 4 удаа хуралдсан бөгөөд тогтоол шийдвэрүүдийг гарган ажиллаж байна.

## 7. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан

Тус компани нь 2014 онд үндсэн үйл ажиллагаагаа эрчимжүүлэх, өмнөх оны үйл ажиллагааны түвшингээс нэмэгдүүлэх зорилтыг тавин ажилласан боловч улс орны эдийн засгийн хэлбэлзэл, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын худалдан авах чадвар, бараа эргэлт багассан зэргээс шалтгаалан үйл ажиллагаа тодорхой хэмжээнд буурсан үзүүлэлттэй гарч байна. Бид ачаа барааны эргэлт буурсан гээд төмөр замын ачилтаа хараад байсангүй, үйл ажиллагаагаа хэвийн явуулах тал

дээр анхаарч өөрсдийн зүгээс төмөр замын тээврээс гадна худалдаа, гадаад тээвэрлэлт / салхин сэнс/ авто тээврийн ачааг тодорхой хэмжээнд явуулж үзэж байгаа зарим тал дээр алдаа оноотой байгаа ч бидний шинэ ажлын эхлэл болж байна.

УБТЗ-н Замын Үүд өртөөний удирдлага болон манай компанитай үйл ажиллагаагаар хамтарч ажилладаг цех тасаг, албадуудтай салбар зам ашиглах гэрээний үүргийн дагуу харилцан уялдаа холбоотой ажилласан. Энэ ажлын хүрээнд ололтой талууд болон бидний зүгээс хамааралгүй, төлөвлөсөн ажил биелэхгүй асуудал тулгарч байсан ч энэ бүх бэрхшээлийг хамтын хүчээр даван гарсан. Вагон хангалт болон ачигдсан вагонуудын таталт дээр энэ жил илүү анхаарч ажилласан нь үр дүнгээ өгсөн билээ.


Замын Үүд өртөөний удирдлагатай хамтарч улирал тус бүр дээр Салбар зам ашиглах вагон тавьж өгөх, татаж авах гэрээний дүнгийн хурал дээр манай компаний үйл ажиллагааны талаар болон өртөө цехийн, албадуудтай яаж үр дүнтэй хамтарч ажиллах, тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцэж цаашид илүү оновчтой ажиллах арга замыг эрэлхийлсэн.

Энэ онд нийт 3539 вагонд ачилт хийсэн ба энэ ачигдсан вагоны 2184 нь цемент, үлдсэн 1355 нь барилгын материал болон бусад төрлийн ачаа ачигдсан байна. 2014 оны ачилтыг 2012 болон 2013 оны ачилттай харьцуулахад:

Сар	2012 он	2014 он	Зөрүү	Хувь өсөлт бууралт
Ачсан вагоны тоо	4445	3539	-906	-20.4% буурсан

Сар	2013 он	2014 он	Зөрүү	Хувь өсөлт бууралт
Ачсан вагоны тоо	3,881	3539	-342	-8.8% буурсан

2014 оны ачилтын өсөлт бууралтыг графикаар харуулбал:



2012 онтой харьцуулахад ачилт 20.4%-иар, 2013 онтой харьцуулахад 8.8%-иар тус тус буурсан байна. Энэ нь тээвэрлэлт жилээс жилд буурч байгаа нь эдийн засгийн өнөөгийн хямрал, юаны ханш өмнөх онтой харьцуулахад 280-311 болж өссөн нөгөө талаас Улаанбаатараас Замын үүдийг холбосон авто зам ашиглалтанд орсноор авто замын тээвэрлэлт нэмэгдсэн.

Монголын алт ХХК, НВЦ ХХК-тай материал нийлүүлэх, авто тээврийн болон чингэлэгийн тээвэр хийсэн нь нэг талаас шинэ ажил болсон ч нөгөө талаас, авто тээврийн үйлчилгээг өөрийн автомашингүй бол тээвэрлэлт хийхэд цаг хугацааг гэрээний хугацаанд нийлүүлэх, ханшийн зөрүү, тээврийн хөлсийг нарийн тооцож гаргах зэргээс үүдэн бидэнд алдаатай оноотой зүйл байлаа. Энэ чиглэлийн тээврийг хувь хүмүүс их хийдэг болсон нь тээврийн үнэ ханшийг буулгаж бидний тооцоолж байснаар болоогүй нь хойшид бас юунд анхаарах зэрэг олон сургамж болсон. Манай компани нь хятад улсаас автозамаар тээвэрлэгдэн ирсэн салхин сэнсний далбааг өөрийн талбай дээр буулган, салбар замаас Монголд улсад анх удаа хамгийн урт ачаа болох салхин сэнсний далбааг тавцант вагонд ачиж, бэхлэх бэхэлгээг "Э Транс Ложистикс" ХК-ний ажилчид болон Олон улсын тээврийн "Ларгус" компанийн ажилчидтай хамтарч ажилласан нь бидний хувьд ажлын туршлага солилцсон жил байлаа. Салхин сэнсний далбааг ачих ачилт 5-р сараас эхлээд 12-р сар хүртэл нийтдээ 27н хос буюу 54 ширхэг салхин сэнсийг ачин нийт 21,000,000 сая төгрөгний орлого олсон ба үүнд НӨАТ-ын үнэ орсон болно.

Цаашид өөрсдийн үйл ажиллагааг цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор гаалийн зуучлалын үйл ажиллагааг явуулах, өөрсдийн гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнг суулгах, худалдаа тээврийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх, тээврийг гаалийн бүрдүүлэлт тээвэрлэлттэй нь авч үйлчлүүлэгчдийн цар хүрээг нэмэг боловсон хүчний талаар

Замын үүд суманд үйл ажиллагаагаа явуулахад ажиллах хүчний тогтвор суурьшил муу шилжилт хөдөлгөөн их байдагтай холбоотойгоор ажлын тасралтгүй үйл ажиллагаа явуулах байдал доголдолтой байдаг нь ажилд сөргөөр нөлөөлдөг.

Нийгэм эдийн засгийн хямралтай энэ цаг үед ажилчднхаа мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх, ажлын хариуцлагыг сайжруулах тал дээр анхаарч нягтлан бодогч Э.Ариунтуяаг "Хямралаас гарах арга зам" Талбайн эрхлэгч Г.Оюунгэрэл, менежер Х.Батхишиг, тээврийн ахлах мэргэжилтэн В.Баасансүрэн нарыг "Хөдөлмөрийн аюулгүй байдлын" сургалтанд тус тус хамрагдсан. Бид ажилгүй хямралаа гээд ажилчидаа халсангүй харин тэднийг энэ үед өөрсдийг нь хөгжүүлэх мэргэшүүлэх тал дээр анхаарч ажиллаж байна. Хямралыг бид бас эерэгээр хүмүүн капиталаа чадавхжуулах цаг хугацааны шалгалт гэж ойлгож байгаа. Ажилчдын амралт чөлөөлт цагийн зөв боловсон өнгөрүүлэх, тэднийг шагнаан урамшуулах, ажлын идэвхи чармайлтыг нэмэгдүүлэх үүднээс Энэ оны 7-р сар, 10-р сард нийт 15-н хүнийг Замын үүдээс-Бээжин-Чинханду хүртэл 5 хоногийн хугацаатай аялуулсан. Ажилчдын дунд урлаг спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулж, сургах, хөгжих тал дээр дэмжин ажиллаж байна.

#### Дотоод ажлын хүрээнд

Гаалийн хяналтын бүсэд тавигдсан шаардлагын дагуу гадна талбай, дотор камерийн хяналтын асуудлуудыг иж бүрэн шинэчлэж, гаалийн ахлах байцаагчийн

ерөөнд тусд нь ГХБ хянах боломжийг бүрдүүлж өгсөн. Төмөр замын суурин интернэтийг шилэн кабельд холбосон нь интернэтийн доголдолыг арилгаж, хурдыг нэмэгдүүлсэн нь гаалийн бүрдүүлэлттэй холбоотой бичиг баримтуудыг интернэтээс шалтгаалан саатдаг байсан бол энэ асуудлыг шийдэж чадсан.

Байгууллагын гаднах тохижилт болон "Ногоон байгууламж бидний орчин" гэсэн аяныг ажилчдын дунд өрнүүлэн байгууллагны эргэн тойронд 4-н төрлийн 500ш мод, цэцгийн мандал, дотор оффис ажлын өрөөнүүдэд 8-төрлийн 50иад ширхэг цэцгийг үрслүүлсэн, гадна талд нарны зайн хураагууртай гэрэл суулгаж, гаалийн хяналтын бүсийн хаяг, байгууллагынхаа хаягыг гэрлэн хаягаар өөрчлөн гадна тохижилт өнгө үзэмжийг сайжруулсан.

8. Манай компани нь монголын компанийн засаглалын кодексыг мөрдөн ажиллаж байгаа ба тухай бүр СЗХ, МХБ, өөрийн веб сайт, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр компанийн хувьцаа эзэмшигч, олон нийтэд компанийн мэдээллийг хүргэн ажиллаж байна.

### III. ТАЙЛАНГИЙН ГУРАВДАХЬ ХЭСЭГ

Компанийн 2012, 2013, 2014 оны орлогын тайлангийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

/сая.төгрөгөөр/

Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он
Борлуулалт	5802,2	5428,4	5398,9
Борлуулалтын хөнгөлөлт	-	-	-
Цэвэр борлуулалт	5802,2	5428,4	5398,9
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		4429,1	4819,4
Нийт ашиг		999,3	579,5
Үйл ажиллагааны зардал	5628,7	842,2	478,2
Үйл ажиллагааны ашиг /алдагдал/	173,56	157,1	101,3
Үйл ажиллагааны бус зардал		74,7	41,7
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	111,9	82,3	59,6
Орлогын татварын зардал	16,0	9,1	16,7
Цэвэр ашиг, алдагдал	95,9	73,2	42,9

Компанийн 2012, 2013, 2014 оны хөрөнгө, эх үүсвэрийн тэнцлийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

/сая.төгрөгөөр/

Хөрөнгө, өр төлбөрийн үзүүлэлтүүд	2012 он	2013 он	2014 он 2р улирал
Эргэлтийн хөрөнгө	71,7	131,9	134,2
Эргэлтийн бус хөрөнгө	6676,7	6549,7	6320,1
Нийт хөрөнгийн дүн	6748,7	6681,6	6454,3
Богино хугацаат өр төлбөр	989,8	849,5	579,2
Урт хугацаат өр төлбөр	0	0	
Эзэмшигчдийн өмчийн дүн	5758,8	5832,1	5875,1



Өр төлбөр, эзэмшигчийн өмчийн дүн	6748,7	6681,6	6454,3
-----------------------------------	--------	--------	--------

Сүүлийн 3 жилийн дэлгэрэнгүй санхүүгийн тайланг дараах линкээр орж танилцана уу. <http://mse.mn/company/finance/code/537>

Компани нь 2014 оны 04 сарын 28-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2013 оны үйл ажиллагааны тайлан
2. Компанийн 2013 оны санхүүгийн тайлан, хараат бус аудитын дүгнэлт
3. Компанийн аудитын хорооны тайлан
4. 2014 оны ажлын төлөвлөгөөг батлах
5. ТУЗ-ийн энгийн болон хараат бус гишүүдийг сонгох
6. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын 2014 оны зардлын төсвийг батлах
7. Ногдол ашиг тараах эсэх

Компани нь 2013 оны 04 сарын 29-ний өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
2. Компанийн 2012 оны бизнес үйл ажиллагааны тайлан
3. Компанийн 2013 оны бизнес төлөвлөгөөг батлах
4. Компанийн аудитын хорооны тайлан
5. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
6. ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв
7. Ногдол ашиг тараах эсэх

Компани нь 2012 оны 04 сарын 30-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
2. Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан, 2012 оны бизнес төлөвлөгөө
3. Хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах тухай
4. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга
5. Компанийн засаглалын 5 журам
6. ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох
7. ТУЗ-ийн зардлын төсвийг батлах
8. Бусад